

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2025/147/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2025 он	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор/Аудитор: Б.Алтанцэцэг Утас: 8000-7121 Цахим хаяг: Tolinetugen@gmail.com Аудитор Г.Шүрэнцэцэг Утас: 8905-6740 Цахим хаяг: Tolinetugen@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
3.1 Төлбөрийн акт.....	12
3.2 Албан шаардлага	12
3.3 Зөвлөмж	12
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025-02-25 № 1-6/217

танай _____-ны № _____-т

САЙНШАНД СУМЫН ЗҮҮНБАЯНГИЙН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.БУДСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Зүүнбаян сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

442502095

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бүтэц орон тоонд батлагдаагүй архив бичиг хэргийн ажилтныг слесарьд хариуцуулан 2024 оны 1-5 сард нийт 1,473.8 мянган төгрөгийг, 10-12 сард бүлгийн багшид хариуцуулан 1,250.4 мянган төгрөгийг тус тус олгосон байна. Мөн няравт Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтныг хариуцуулан 1,632.1 мянган төгрөгийг олгосон боловч ажлын тайлан гүйцэтгэл байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 93.0% хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	119,658,010.00	126,939,451.84
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	63,652,081.64	73,238,143.48
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	63,652,081.64	73,238,143.48
3121	Төгрөг	63,652,081.64	73,238,143.48
31211	Төрийн сангийн харилцах	63,652,081.64	73,238,143.48
33	АВЛАГА	585,829.00	1,302,314.00
335	Бусад авлага	585,829.00	1,302,314.00
3351	Байгууллагаас авах авлага	585,829.00	1,302,314.00
35	БАРАА МАТЕРИАЛ	55,420,099.36	52,398,994.36
351	Түүхий эд материал	4,578,100.00	4,578,100.00
35110	Тусгай зориулалттай материал	4,578,100.00	4,578,100.00
354	Хангамжийн материал	50,841,999.36	47,820,894.36
35410	Бичиг хэргийн материал	-	423,500.00
35420	Аж ахуйн материал	40,926,409.29	37,594,049.29
35440	Түлш, шатах тослох материал	0.07	0.07
35450	Барилгын засварын материал	-	869,200.00
35460	Хүнсний материал	6,776,390.00	1,367,845.00
35470	Бусад хангамжийн материал	3,139,200.00	7,566,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	556,235,163.45	524,282,538.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	556,235,163.45	524,282,538.89
392	Биет хөрөнгө	503,507,246.49	471,698,538.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	592,502,235.00	592,502,235.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(108,624,176.75)	(132,324,266.15)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	66,563,285.00	42,554,960.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(56,970,217.77)	(34,814,532.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	106,267,208.26	79,150,378.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	(96,907,546.21)	(75,438,235.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,315,000.00	13,815,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(19,300,000.00)	(13,800,000.00)
39217	Ном	661,458.96	53,000.00
393	Биет бус хөрөнгө	52,727,916.96	52,584,000.00
39301	Програм хангамж	1,727,000.00	1,727,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,583,083.04)	(1,727,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	52,584,000.00	52,584,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	675,893,173.45	651,221,990.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,524,000.00	2,450,800.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,524,000.00	2,450,400.00
413	Өглөг	1,524,000.00	2,450,400.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,446,000.00	2,260,000.00
4136	Бусад өглөг	78,000.00	190,400.00
41361	Байгууллагад төлөх өглөг	78,000.00	87,400.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	103,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	673,555,173.45	648,771,590.73
51	Засгийн газрын хувь оролцоо	673,555,173.45	648,771,590.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	480,946,136.05	480,946,136.05
51101	Өмч: - төрийн	480,946,136.05	480,946,136.05
512	Хуримтлагдсан үр дүн	192,609,037.40	167,825,454.68
51210	Өмнөх үеийн үр дүн	192,609,037.40	192,609,037.40
51220	Тайлант үеийн үр дүн	-	(24,783,582.72)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	675,079,173.45	651,221,990.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	666,668,955.15	882,261,609.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,047,504.00	1,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,047,504.00	1,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,047,504.00	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,047,504.00	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	663,621,451.15	881,261,609.89
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	624,272,500.00	829,779,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	624,272,500.00	829,779,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,348,951.15	51,481,909.89
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,348,951.15	51,481,909.89
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	653,256,151.14	906,436,733.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	653,256,151.14	906,436,733.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	644,332,451.14	906,436,733.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,437,191.24	685,371,566.26
210101	Үндсэн цалин	332,505,786.25	436,062,272.50
210102	Нэмэгдэл	98,480,608.61	227,059,673.76
210104	Урамшуулал	19,450,796.38	22,249,620.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,567,708.58	77,725,116.90
210201	Тэтгэврийн даатгал	36,088,708.58	51,374,087.03
210202	Тэтгэмжийн даатгал	4,870,000.00	6,705,699.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,001,300.00	3,327,876.49
210204	Ажилгүйдлийн даатгал	868,400.00	3,235,799.57
210205	Эрүүл мэндийн даатгал	9,739,300.00	13,081,654.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,948,951.15	48,923,009.89
210301	Гэрэл, цахилгаан	9,777,552.15	10,648,366.89
210302	Түлш, халаалт	25,862,375.00	32,483,100.00
210303	Цэвэр, бохир ус	3,309,024.00	5,791,543.00
2104	Хангамж, бараа материалын зардал	78,000.00	3,913,450.00
210401	Бичиг хэрэг	-	736,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	78,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,177,050.00
2105	Нормативт зардал	44,327,523.00	45,140,055.00
210502	Хоол, хүнс	44,327,523.00	45,140,055.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	814,000.00	4,580,260.00
210604	Урсгал засвар	814,000.00	4,580,260.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	875,000.00	785,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	875,000.00	785,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,284,077.17	39,998,275.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,876,535.60	3,818,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,536,400.00	2,883,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,871,141.57	33,295,975.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,923,700.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,923,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,923,700.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,412,804.01	(24,175,123.76)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	608,458.96
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	-	608,458.96
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(608,458.96)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	13,412,804.01	(24,783,582.72)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	666,668,955.15	882,261,609.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,047,504.00	1,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,047,504.00	1,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,047,504.00	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,047,504.00	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	663,621,451.15	881,261,609.89
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	624,272,500.00	829,779,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	624,272,500.00	829,779,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,348,951.15	51,481,909.89
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,348,951.15	51,481,909.89
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	613,263,295.93	870,723,738.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	613,263,295.93	870,723,738.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	604,339,595.93	870,723,738.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,896,926.20	685,371,566.26
210101	Үндсэн цалин	310,093,260.11	436,062,272.50
210102	Нэмэгдэл	121,352,869.71	227,059,673.76
210104	Урамшуулал	19,450,796.38	22,249,620.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,567,708.58	77,725,116.90
210201	Тэтгэврийн даатгал	36,088,708.58	51,374,087.03
210202	Тэтгэмжийн даатгал	4,870,000.00	6,705,699.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,895,700.00	3,327,876.49
210204	Ажилгүйдлийн даатгал	974,000.00	3,235,799.57
210205	Эрүүл мэндийн даатгал	9,739,300.00	13,081,654.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,948,951.15	48,923,009.89
210301	Гэрэл, цахилгаан	9,777,552.15	10,648,366.89
210302	Түлш, халаалт	25,862,375.00	32,483,100.00
210303	Цэвэр, бохир ус	3,309,024.00	5,791,543.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2105	Нормативт зардал	38,741,810.00	40,447,995.00
210502	Хоол, хүнс	38,741,810.00	40,447,995.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	400,000.00	2,558,900.00
210604	Урсгал засвар	400,000.00	2,558,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	875,000.00	779,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	875,000.00	779,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,909,200.00	14,917,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,163,500.00	9,413,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,745,700.00	5,504,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,923,700.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,923,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,923,700.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	53,405,659.22	11,537,871.84
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,951,810.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,951,810.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,951,810.00
222001	Тоног төхөөрөмж	-	1,951,810.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(1,951,810.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	53,405,659.22	9,586,061.84
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	63,652,081.64
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	63,652,081.64	73,238,143.48

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНИЙ НИЙТ ДҮН
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	480,946,136.05		179,196,233.39	660,142,369.44
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	480,946,136.05	-	179,196,233.39	660,142,369.44
Тайлант үеийн үр дүн			13,412,804.01	13,412,804.01
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	480,946,136.05	-	192,609,037.40	673,555,173.45
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	480,946,136.05	-	192,609,037.40	673,555,173.45
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	480,946,136.05	-	192,609,037.40	673,555,173.45
Тайлант үеийн үр дүн			(24,783,582.70)	(24,783,582.70)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	480,946,136.05	-	167,825,454.70	648,771,590.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	937,980,900.00	872,675,548.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	937,980,900.00	872,675,548.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	937,980,900.00	872,675,548.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	735,755,900.00	685,371,566.26
210101	Үндсэн цалин	483,333,500.00	436,062,272.50
210102	Нэмэгдэл	230,171,800.00	227,059,673.76
210104	Урамшуулал	22,250,600.00	22,249,620.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,713,100.00	77,725,116.90
210201	Тэтгэврийн даатгал	59,646,100.00	51,374,087.03
210202	Тэтгэмжийн даатгал	7,016,000.00	6,705,699.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,508,400.00	3,327,876.49
210204	Ажилгүйдлийн даатгал	3,508,400.00	3,235,799.57
210205	Эрүүл мэндийн даатгал	14,034,200.00	13,081,654.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,549,300.00	48,923,009.89
210301	Гэрэл, цахилгаан	12,720,000.00	10,648,366.89
210302	Түлш, халаалт	20,625,100.00	32,483,100.00
210303	Цэвэр, бохир ус	8,204,200.00	5,791,543.00
2105	Нормативт зардал	47,550,500.00	40,447,995.00
210502	Хоол, хүнс	47,550,500.00	40,447,995.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	2,558,900.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,558,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,858,700.00	779,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,858,700.00	779,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,553,400.00	16,869,760.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,049,300.00	11,365,660.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,504,100.00	5,504,100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	937,980,900.00	882,261,609.89
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	893,431,600.00	831,539,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	893,431,600.00	831,539,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	44,549,300.00	49,721,909.89
132001	Орон нутгийн төсвөөс	44,549,300.00	49,721,909.89
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,000,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		63,652,081.64
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		73,238,143.48

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 28,878.5 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс 28,878.5 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч ажилласан.

Аудитаар илэрсэн зөрчлийн 28,878.5 мянган төгрөгийн зөрчлөөс 22,410.2 мянган төгрөг нь нийцлийн аудитад хамаарч санхүүгийн аудитад хамаарах 6,468.3 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин болох 9798.8 мянган төгрөгөөс бага байх тул “Өөрчлөлтгүй. дүгнэлт өгсөн

3.1 Төлбөрийн акт

2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

3.2 Албан шаардлага

2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага тогтоогдоогүй болно.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт:

Тайлант 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар Бат үндэс ХХК-д 1.446.0 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна. Гэтэл байгууллага хоорондын тооцоо нийлсэн актаар өр, авлагагүй гэж баталгаажуулсан зөрчил байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх", "үнэн зөв байх" батламж мэдэгдэлтэй нийцүүлж ажиллаж.

Илрүүлэлт:

Тус цэцэрлэг нь тайлант 2024 оны 1-9 дүгээр саруудад 5 аж ахуйн нэгж байгууллага, 2 иргэнээс худалдан авалтын гэрээгүйгээр 22,410.2 мянган төгрөгийн хоол хүнсний материалыг худалдан авсан байна.

Өгсөн зөвлөмж:

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2. “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” заалтыг хэрэгжүүлж ажиллах, худалдан авалтын гэрээ байгуулж ажиллах.

Илрүүлэлт:

Бүтэц орон тоонд батлагдаагүй архив бичиг хэргийн ажилтныг слесарь Б.Батхүрэлд хариуцуулан 2024 оны 1-5 сард нийт 1,473.8 мянган төгрөгийг, 10-12 сард бүлгийн багш М.Батгэрэлд хариуцуулан 1,250.4 мянган төгрөгийг тус тус олгосон байна. Мөн нярав Б.Тэгшмандалд Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн

ажилтныг хариуцуулан 1,632.1 мянган төгрөгийг олгосон боловч ажлын тайлан гүйцэтгэл байхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах заалтыг хэрэгжүүлж, батлагдсан бүтэц орон тооны хүрээнд ажиллах.

Илрүүлэлт:

2024 оны санхүүгийн байдлын тайланд 2,450.8 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл тайлагнасан байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8. *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* заалтыг хэрэгжүүлж өр авлага үүсгэхгүй, төсвийг зохистой удирдаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар Бат үндэс ХХК-д 1.446.0 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна. Гэтэл байгууллага хоорондын тооцоо нийлсэн актаар өр, авлагагүй гэж баталгаажуулсан зөрчил байна	1	1,446.0					1	1,446.0		
Тус цэцэрлэг нь тайлант 2024 оны 1-9 дүгээр саруудад 5 аж ахуйн нэгж байгууллага, 2 иргэнээс худалдан авалтын гэрээгүйгээр 22,410.2 мянган төгрөгийн хоол хүнсний материалыг худалдан авсан байна.	1	22,410.2					1	22,410.2		
Бүтэц орон тоонд батлагдаагүй архив бичиг хэргийн ажилтныг слесэрь Б.Батхүрэлд хариуцуулан 2024 оны 1-5 сард нийт 1,473.8 мянган төгрөгийг, 10-12 сард бүлгийн багш М.Батгэрэлд хариуцуулан 1,250.4 мянган төгрөгийг тус тус олгосон байна. Мөн нярав Б.Тэгшмандалд Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтныг хариуцуулан 1,632.1 мянган төгрөгийг олгосон боловч ажлын тайлан гүйцэтгэл байхгүй байна.	1	4,356.3					1	4,356.3		
2024 оны санхүүгийн байдлын тайланд 2,450.8 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл тайлагнасан байна.	1	2,450.8					1	2,450.8		
Нийт	4	28,212.5	-	-	-	-	3	28,212.5	-	-